ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өвөрхангай аймгийн Халамжийн сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ӨВА-2023/245/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn

Өвөрхангай аймаг,
Арвайхээр сум

2023 он

Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор: О.Батжаргал
Утас: 70323253 Цахим хаяг: batjargalo@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Гансүх
Утас: 70323833 Цахим хаяг: gansukh.audit@gmail.com
Аудитор: Ө.Ринчинмядаг
Утас: 70323108 Цахим хаяг: rinchinmyadagu@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173.
Утас/Факс: (976) 7032 3253.
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn.
Цахим хуудас: www.audit.mn

2023. 02. 16 №24
танай __________-ны №__________-т

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Т.НАРАНГАРАВ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өвөрхангай аймгийн Халамжийн сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд улсын төсвөөс 267.16 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. 2022 оны эхний улиралд улсын хэмжээнд нийгмийн халамжийн үйлчилгээ и-халамж буюу цахим хэлбэрт бүрэн шилжсэнтэй холбоотой улсын төсвийн санхүүжилт хийгддэг, нийгмийн халамжийн сангаас олгож буй тэтгэвэр, тэтгэмж олгоход ашиглагдаж байсан арилжааны банкин дахь данснууд хаагдаж, нийгмийн халамжийн цахим программ дахь үйлчилгээнд хамрагдах иргэдийн жагсаалтын дагуу гүйлгээг Сангийн яамнаас шилжүүлдэг болсон. Үүнтэй холбоотой 2022 оны 02 дугаар сараас эхлэн аймаг дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүдэд улсын төсвийн орлого, зарлагын гүйлгээ хийгдэхгүй болсон.

**Аудитын гол асуудал**

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Тус байгууллага нь Ахмад настны нийгмийн хамгааллын тусламж, хөнгөлөлтийн зарцуулалтад 114.87 сая, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлтийн зардалд 16.9 сая, Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний зарцуулалтад 129.4 сая, банкны шимтгэл 0.47 сая төгрөг тус тус зарцуулсан бөгөөд улсын төсөвт 5.4 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

01503042

D:\New Volume\2023 on\Bichig khereg\A4

**Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

D:\New Volume\2023 on\Bichig khereg\A4

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | - | - |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | - | - |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | - | - |
| 3121 | Төгрөг | - | - |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | | - |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | - | - |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | - | - |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | - | - |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | - | - |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 876,612.96 | - |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (876,612.96) | - |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | - | - |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 8,030,300,061.07 | 267,159,400.0 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 10,061.07 | - |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 10,061.07 | - |
| 120002 | Хүүгийн орлого | 10,061.07 | - |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 8,030,290,000.00 | 267,159,400.0 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 8,030,290,000.00 | 267,159,400.0 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 8,030,290,000.00 | 267,159,400.0 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 8,031,176,674.03 | 267,159,400.0 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 8,031,176,674.03 | 267,159,400.0 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 8,009,548,485.00 | 261,740,380.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 8,009,548,485.00 | 261,740,380.0 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 3,327,950.00 | 471,400.00 |
| 210813 | Бусад зардал /ТӨҮГ/ | 8,006,220,535.00 | 261,268,980.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 21,628,189.03 | 5,419,020.0 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 21,628,189.03 | 5,419,020.0 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 21,628,189.03 | 5,419,020.0 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | -876612.96 | - |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | -876612.96 | - |

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 8,081,513,176.07 | 267,159,400.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 51,223,176.07 | - |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 51,223,176.07 | - |
| 120002 | Хүүгийн орлого | 10,061.07 | - |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 51,213,115.00 | - |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 51,213,115.00 | - |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 8,030,290,000.00 | 267,159,400.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 8,030,290,000.00 | |

| | | | |
|---|---|---|---|
| | | | 267,159,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 8,030,290,000.00 | 267,159,400.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **8,082,389,789.03** | **267,159,400.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **8,082,389,789.03** | **267,159,400.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **8,060,761,600.00** | **261,740,380.00** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 8,060,761,600.00 | 261,740,380.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 3,327,950.00 | 471,400.00 |
| 210818 | Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/ | 8,057,433,650.00 | 261,268,980.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **21,628,189.03** | **5,419,020.00** |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 21,628,189.03 | 5,419,020.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 21,628,189.03 | 5,419,020.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **-876612.96** | **0.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | (876,612.96) | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 876,612.96 | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | | | 876,612.96 | | 876,612.96 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | 0.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **0.00** | **0.00** | **876,612.96** | **0.00** | 876,612.96 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | | 0.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | | 0.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | -876,612.96 | | -876,612.96 |
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **0.00** | **0.00** | **876,612.96** | **0.00** | 876,612.96 |
| D01 | **2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **0.00** | **0.00** | **0.00** | **0.00** | 0.00 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | 0.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **0.00** | **0.00** | | **0.00** | 0.00 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | | 0.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | | 0.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | 0.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | | 0.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 876,612.96 | | - |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | - | 8,060,761,600.00 | - | 261,740,380.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | - | 8,060,761,600.00 | - | 261,740,380.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 0.00 | 3,327,950.00 | 0.00 | 471,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 0.00 | 3,327,950.00 | 0.00 | 471,400.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | | 3,327,950.00 | | 471,400.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | 8,057,433,650.00 | - | 261,268,980.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 8,057,433,650.00 | - | 261,268,980.00 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | | 8,057,433,650.00 | | 261,268,980.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 8,030,290,000.00 | 8,030,290,000.00 | 267,159,400.00 | 267,159,400.00 |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант онд нэмэлт санхүүжилт байхгүй болно.

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

### 3.1 Төлбөрийн акт

Байхгүй болно.

### 3.2 Албан шаардлага

Байхгүй болно.

### 3.3 Зөвлөмж

Байхгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Дүн | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| Дүн | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Байхгүй | - | - | - | - | - | - | - | - |
| Дүн | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Байхгүй | - | - | - | - | - | - | - | - |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | - | - | - | - | - | - | - | - |

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР